



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 674

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Дорнод аймгийн Татварын газрын хүүхдийн өрөөний тохижилт” ажлын хүрээнд бий болсон, нийт 13,920,913.00 (арван гурван сая есөн зуун хорин мянга есөн зуун арван гурав) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Дорнод аймгийн Татварын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Дорнод аймгийн Татварын газрын дарга С.Бямбарагчаад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
.....674..... дугаар тогтоолын хавсралт

**ДОРНОД АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Зурагт 55 инч	2024.08.21	ш	1	3,000,000.00	3,000,000.00
2	Суурин компьютер	2024.08.21	ш	1	5,500,000.00	5,500,000.00
3	Сурагчийн ширээ	2024.08.21	ш	1	560,000.00	560,000.00
4	Сурагчийн сандал	2024.08.21	ш	6	95,000.00	570,000.00
5	Хүүхдийн ширээ	2024.08.21	ш	1	350,000.00	350,000.00
6	Ханын тавиур	2024.08.21	ш	1	820,000.00	820,000.00
7	Эд хогшлын тавиур	2024.08.21	ш	1	870,913.00	870,913.00
8	Модон хаалга/өрөөний/	2024.08.21	ш	1	750,000.00	750,000.00
9	Ханын тавиур том	2024.08.21	ш	2	750,000.00	1,500,000.00
Нийт дүн						13,920,913.00
						(арван гурван сая есөн зуун хорин мянга есөн зуун арван гурав)